

**Б.МӨНГӨНЦЭЦЭГИЙН “МОНГОЛ ХЭЛНИЙ ОЙРОЛЦОО ЗЭРГЭД” НОМЫН
ТУХАЙ**

Ж.Бат-Ирээдүй¹

Монгол хэлний үгийн сан, утга судлалын нэгэн чухал нэгж болсон ойролцоо утгын тухай судалгаа хийж байхад энэ талын бие даасан нэг сэдэвт зохиол байтугай дорвитой эрдэм шинжилгээний өгүүлэл ч тун ховор байдаг юм. Харин МУИС-ийн МХСС-ийн Хэлшинжлэлийн Тэнхимийн багш, доктор (Ph.D) Б.Мөнгөнцэцэг бээр өөрийн докторын зэрэг хамгаалсан “Монгол хэлний ойролцоо зэргэд” хэмээх нэгэн сэдэвт зохиолоо ном болгон хэвлүүлсэн нь энэ төрлийн судалгаа хийдэг гадаад дотоодын судлаачид, монгол хэл бичгийн багш, оюутан, аспирант, докторант нарт тун чухал гарын авлага болжээ. Эл ном нь B5-ын форматтай, нийт 184 хуудастай, зөөлөн хавтастай, ISBN 999626087-9.

Энэхүү ном нь Удиртгал болон монгол хэлний ойролцоо үг, түүний утгын ангилал, монгол хэлний ойролцоо зэргэд, түүний ангилал, дүгнэлт, аннотация, номзүй, зарим нэр томъёоны хэлхээ, нэрийн хэлхээ, хавсралт гэсэн үндсэн хэсгүүдтэй бөгөөд номын үндсэн гол агуулга, зорилт 1, 2 дугаар бүлэгт багтсан байна.

Профессор М.Базарраг чаа бээр эл номд “Монгол хэлний ойролцоо нэгжийг судлах асуудалд” хэмээх судалгааны өгүүлэлээ өмнөх үг болгон хэвлүүлж, “... түвшдийн нэгж болгоныг –ойролцоо ба төсөөт, эсрэг ба зүйлчлэл, ижил ба салаа утга- гэхчлэн “нэвт сүлбэн” судалж байна” гэж энэхүү судалгааны нэгэн гол учир зорилгыг тодорхойлжээ.

Удиртгал бүлэгт хэлний ойролцоо үг, өгүүлбэрийн тухай, тэрдундаа зэргэд буюу параллелизм-ын тухай хэлшинжлэлийн үүднээс дэлгэрэнгүй тайлбарлаж монгол хэлний ойролцоо үг, өгүүлбэр, зэргэдийг мэдэгдэхүүн, хэлэгдэхүүн, хэлэхүүн, мэдэхүүний талаас хэрхэн ухах ойлгох талаар дурдаж хэлний нэгжүүдийг ижилсэх, ондооших, талаас тайлбарлаж, хэлний найруулах ур маягт зэргэдийг хэн хаана хэрхэн судалж дурдсан талаар зүүлт хийж үзүүлжээ.

Мөн энэ номд монгол хэлний ойролцоо, үг өгүүлбэрийг судалсан түүхийн тоймыг дурдаж, үг, өгүүлбэрийг судалсан, тухай тус тус дэлгэрэнгүй дурдаж өөрийн дүгнэлтийг хэсэг бүлэг бүрт хийжээ.

Монгол хэлний ойролцоо үг, түүний утгын ангилал нэгдүгээр бүлэгт, хэлний нэгж бүр ойролцоо утгатай байж болно гэдэг онолыг барин судалгаа хийж, монгол хэлний ойролцоо үгийг судалсан өмнөх үеийн судлаачдын судалгааг нягтлан үзэж, мөн орчин үеийн хэлшинжлэл түүний дотор семантикийн онолын үүднээс гадаадын эрдэмтэн судлаачид хэрхэн үзэхийг авч үзэн, “Монгол хэлний ойролцоо үг үүсэх эх сурвалжийг нэг талаас, бодит юм үзэгдэлтэй шууд холбоо бүхий юмжуулах харьцаанд, нөгөө талаас, юм үзэгдэлтэй шууд холбоогүй, харин юмын

1. Монгол Улсын Их Сургууль

шинж чанар, хөдөлгөөнтэй холбоотой дохиожуулах харьцаанд үндэслэдэг гэж үзэж болно.”² гэжээ. Мөн монгол хэлний ойролцоо үгийг мэдэгдэхүүний талаас бодит утга бүхий туйлын ойролцоо үг, бодит утга бүхий оновчтой ойролцоо үг, хэлэгдэхүүний үүднээс хийсвэр утга бүхий туйлын ойролцоо үг, хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг, хэлэхүүний талаас хийсвэр утга бүхий оновчтой бус ойролцоо үг, хийсвэр утга бүхий хуурмаг ойролцоо үг, мэдэхүүний талаас бодит утга бүхий оновчтой бус ойролцоо үг, бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг гэж тус тус ялгаж болно гээд монгол хэлний тодорхой жишээгээр үзүүлж, “гаргалгаараа бүрэн ондоошиж, агуулгаараа бүрэн ба бүрэн бус тохирох үгсийг ойролцоо үг, өөрөөр хэлбэл адил бусын адил нэгжийг ойролцоо нэгж” хэмээн тодорхойлж болно”³ гэж дүгнэжээ.

Мөн энэ бүлэгт авч үзсэн бас нэг чухал асуудал ойролцоо үг, төсөөт үгийг хэрхэн ялгах тухай асуудал байна. Учир нь хэлшинжлэлд тэмдэглэхүүн ба тэмдэглэгдэхүүний хувьд хагас тохирдог нэг харахад утга ойролцоо юм шиг, нөгөө үзэхүл ойролцоо биш юм шиг байдаг ойролцоо үгийг төсөөт үгээс ялгах төвөгтэй асуудлыг хөндөж “монгол хэлний ойролцоо үг, төсөөт үгийн ижилсэх болон ондооших талыг хэлний баримт дээр тайлбарласны зэрэгцээ төсөөрхүү үг, үгийн хувилбараас ялган авч үзээд, монгол хэлний ойролцоо үг, төсөөт үг нь нэгэн адил ижилсэх харьцаанд байдаг хэдий ч тэмдэглэхүүн, тэмдэглэгдэхүүний хувьд эсрэг шинжтэй болох нь харагдаж байна.”⁴ хэмээн дүгнэжээ.

Номын тус бүлгийн дараагийн хэсэгт энэхүү номоо нэрлэсэн “ойролцоо зэргэдийн гол хэрэглүүр нь ойролцоо утгатай үг” болох тухай дэлгэрэнгүй дурдаж, “монгол хэлний ойролцоо зэргэд нь ойролцоо утга бүхий хоршоо үгээс үүдэлтэй байна. Ойролцоо утгат хоршоо үгийн утгын болон авианы ойролцоо байдлыг харгалзан сүүл толгой холбон, мөр тэгшитгэн нэг дор эгнүүлэхээс гадна мөр алгасан салаавчлах байдлаар мөр бадаг тэнцүүлж улмаар мөр мөрт салган зэрэгцүүлсэн нь олонтоо байна” гэжээ. Учир нь монгол хэлний хоршоо үгийн ихэнхийг ойролцоо утгатай үг бүтээдэг бөгөөд энэхүү хэрэглэгдэхүүн нь ойролцоо зэргэд бүтээх үндсэн бааз болж өгдөг тухай энэ хэсэгт жишээ баримттайгаар тайлбарласан байна.

Номын дэд бүлэгт “Монгол хэлний ойролцоо зэргэд болон түүний утгын ангилал”-ын талаар дангаар нь авч үзсэн байх бөгөөд юуны өмнө ойролцоо өгүүлбэрийн тухай хэлшинжлэлийн онолын үүднээс тайлбарлаж, “Ижил санаа бүхий өгүүлбэрүүд нь тухайн бодит юм үзэгдлийн ижил шинжтэй, ойролцоо санаа бүхий өгүүлбэрүүд нь хэд хэдэн юмс үзэгдлийн тухай ойролцоо санаатай тус тус холбогдоно. Үүний эхнийх нь бодит ойролцоо өгүүлбэр болох ба сүүлчийнх нь хийсвэр ойролцоо өгүүлбэр болно. Эдгээр нь найруулгад тэгшлэх (зэргэд), эс тэгшлэх (зэргэд бус) хоёр хэлбэрээр тохиолдож байна”⁵ гэж дүгнэжээ.

Ойролцоо зэргэдээ мэдэгдэхүүний талаас “Ухаан нь ууцандаа, санаа нь сүүжиндээ”, мэдэхүүний талаас. “Дэвсийг нь үзэж морийг нь уях муухай, дээлийг нь үзэж дэвсгэр дэвсэх муухай”, хэлэгдэхүүний талаас. “Нэрээ бүү гээ, хүндээ бүү алд”, хэлэхүүний талаас. “Хамбан дээлийн дотроос хаагүй цамц гарах, халзан хошуутай гутлаас хамаргүй оймс гарах” гэж 4 ялгажээ.

Үүнд хэлэхүүний үүднээс буюу ойролцоо зэргэдийг бүтээж байгаа үйл явдал нь өөр өөр боловч түүнээс үүдэх санаа агуулга нь ойролцоо байх ур маягаас бүтсэн ойролцоо зэргэдийг ил адилтгал буюу зүйрлэлээр үүссэн, адилтгалаар үүссэн, ёгтлолоор үүссэн, егөөдлөөр үүссэн, орлолоор үүссэн, төлөөллөөр үүссэн хэмээн 6 ангилж баримтаар баталжээ.

Харин мэдэхүүний талаас хүний харилцааны талаас үнэлэмж хэрхэн илэрч байгаагаас нь шалтгаалан, эерэг үнэлэмж бүхий, сөрөг үнэлэмж бүхий, эерэг сөрөг үнэлэмж давхар илэрсэн

2. Б.Мөнгөнцэцэг, 2012, “Монгол хэлний ойролцоо зэргэд”, Уб., 40 дэх тал

3. Б.Мөнгөнцэцэг, 2012, “Монгол хэлний ойролцоо зэргэд”, Уб., 74 дэх тал

4. Б.Мөнгөнцэцэг, 2012, “Монгол хэлний ойролцоо зэргэд”, Уб., 81 дэх тал

5. Б.Мөнгөнцэцэг, 2012, “Монгол хэлний ойролцоо зэргэд”, Уб., 94 дэх тал

гэж тус тус ялгажээ.

Уг номд нийт 483 ойролцоо зэргэдийн жишээ сонгосон бөгөөд үүнээс чухам аль төрлийн зэргэд хэд хэчнээн, хэдэн хувьтай байгааг тооцон гаргасан нь ойролцоо зэргэдийн бүрэлдэхүүн болон хэрэглээг тооцож гаргах чухал арга болжээ. Тухайлбал, энд хэлэгдэхүүний ойролцоо зэргэд 54, хэлэхүүний ойролцоо зэргэд 337, мэдэхүүний ойролцоо зэргэд 59 тус тус байгаа ажээ.

Б.Мөнгөнцэцэг, монгол хэлний ойролцоо зэргэдийг цогцолбор бүтээх үндсэн хэрэглүүр болно гэж үзээд “Хэлэхийн цуваа буюу тухайн эхэд утга, хэлбэрийн олон тооны хувилбарууд аяндаа үүсдэг...” гээд адилтгагдахуун болон адилтгахууны аль нэг нь хоосноор илрэх боломж, өгүүлбэрийн эцсийн өгүүлэхийг хураах хэмнэх боломж, яруу найраг, үргэлжилсэн үг, жүжгийн зохиолын ойролцоо зэргэдийг авч үзжээ.

Ингээд уг номын сүүлийн бүлэгт монгол хэлний ойролцоо зэргэдийг судлах явцад “Монгол хэлний их нэгжийг бага нэгжтэй нь харьцуулах, тодруулбал ойролцоо үг, өгүүлбэрийн харьцаанд нь тулгуурлан хэлний агуулга, хэлбэр, ба зогсонги хөдлөнги дөрвөн талаас нь диалектик харьцаанд нь авч үзээд” ойролцоо үгийг туйлын ойролцоо үг, оновчтой ойролцоо үг, оновчтой бус ойролцоо үг, хуурмаг ойролцоо үг гэж ангилаад ойролцоо хоршоо үг нь ойролцоо үг, ойролцоо зэргэд бүтэх эх сурвалж болно” гээд ойролцоо зэргэдээ мэдэгдэхүүн, хэлэгдэхүүн, хэлэхүүн, мэдэхүүний талаас тайлбарлаж, төсөөт зэргэд ойролцоо зэргэдтэй хэрхэн тохирох болон эсрэгцэхийг тайлбарлажээ.

Ийнхүү “Монгол хэлний ойролцоо зэргэд”-ийг тал бүрээс нь дагнан нарийн судласан боловч судалгааны явцад монгол хэлний ойролцоо үг, ойролцоо хэллэг, ойролцоо өгүүлбэрийг хамарсан өргөн судалгаа хийсэн түүний бүтээл нь монгол хэлний үгийн сан утга судлал түүний дотор ойролцоо утгын судалгааг урагшлуулж ахиулсан, өмнө байгаагүй томоохон ахиц авчирсан, намбай, сайн бүтээд болсныг монгол хэлний ойролцоо утгыг судладаг эрдэмтэн хүний хувьд цохон тэмдэглэж байна.

Эцсийн бүлэгт түүний удирдагч багшийн тодорхойлосноор “Б.Мөнгөнцэцэг нь монгол хэлний хэлц зэргэдийг мэдэгдэхүүн ба мэдэхүүн, хэлэгдэхүүн ба хэлэхүүний талаас ялгаж, тус тусын онцлогийг гаргаж, нэлээд чармайн оролдсоныг хянан үзвэл, уг сэдэв нэлээд адармаатай аглаа нэн сонирхолтой болох нь тодорхой байна...” гэсэн тэй санал нэг байгаагаа бас мэдэгдээд энэхүү танилцуулгаа өндөрлөж байна.